

Насан туршийн боловсролын багшийн чадамжийг дэльфи аргаар тодорхойлсон нь

Баттулга Хонгорзул *, Сандуй Эрдэнэцэцэг

Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол Судлалын Сургууль, Насан туршийн боловсрол, зайн сургалтын тэнхим

*Холбоо барих зохиогч: khongorzul@msue.edu.mn

Хүлээн авсан: 2022.10.13

Засварласан: 2022.11.14

Хэвлэлтэд авсан: 2022.12.02

Хураангуй

Багшийг мэргэжлийн байх, мэргэшүүлэх үйл явцын үндэс бол түүний эзэмшвэл зохих мэдлэг, чадвар бөгөөд мэргэшсэн багш болохын тулд ямар чадамж шаардагдах вэ? гэсэн асуулт боловсролын судалгаа, бодлого, эрх зүйн баримт бичгийн хүрээнд тулгамдсан асуудал болсоор байна. Ялангуяа Насан туршийн боловсролын (НТБ)-ын төвийн багш мэргэжилтэнг шинээр бэлтгэх болсон хэдий ч багшийн мэргэжлийн үйл ажиллагааны чиглэл, түүнийг гүйцэтгэхэд шаардлагатай чадамж, ажлын байрны шаардлага тодорхойгүй, мөн ажил мэргэжлийн тодорхойлолт, албан тушаалын тодорхойлолт хараахан шинэчлэгдээгүй (албан бус боловсролын багш) зэрэг асуудал салбарын хэмжээнд тулгамдаж байна. Тиймээс уг өгүүлэлд НТБ-ын багшийн чадамжийг тодорхойлох зорилгоор олон улсын энэ чиглэлийн судалгаанд өргөн ашигладаг дэльфи аргыг хэрэглэн НТБ-ын багшийн мэргэжлийн чадамжийн хүрээг тодорхойлж, уг аргын онцлогт тулгуурлан фокус бүлгийн ярилцлагаар баталгаажуулсан үр дүнг тусгасан болно. НТБ-ын багшийн цогц чадамжийн агуулгыг бид Монгол улсын боловсролын бодлого ялангуяа багш мэргэжлийн стандартын агуулгад баримталж буй жишгийг үндэслэн НТБ-ын багш бие хүний шинж, мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлийн хүрээнд авч үзлээ. Судалгаанд НТБҮТ-ийн (хуучин нэр) мэргэжилтэн, нийслэл, орон нутгийн НТБ-ын төвийн багш, удирдах ажилтан, энэ чиглэлээр суралцаж буй оюутан зэрэг давхардсан тоогоор 110 орчим оролцогч хамрагдав. Судалгааны үр дүнд НТБ-ын багш бие хүний 12 шинж, 51 мэдлэг чадвар, 9 хандлага итгэл үнэмшил, 8 үнэт зүйл гэсэн нийт цогц чадамжийн 80 үзүүлэлт тодорхойлогдсон (кронбахын α дундаж 0.766). Тэдгээрийг НТБ-ын онол, үзэл баримтлал, агуулга, түүнийг хэрэгжүүлэх, судлан шинжлэх; суралцагчдын онцлог, ялгаатай байдлыг харгалзан үзэх, суралцахуйг төлөвлөх, боловсруулах, сургалтын арга зүй тодорхойлох, хэрэгжүүлэх, багшийн мэргэжлийн хөгжлийг хангах, хамтын ажиллагааг бий болгох мэдлэг, чадвар гэсэн мэдлэг чадварын 7 чиглэлээр ангилж болохоор байна.

Түлхүүр үг: Насанд хүрэгчдийн боловсрол, бие хүний шинж, мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйл



Удиртгал

Шинэ зуунд боловсролын талаар дэлхий нийтээр баримтлах чиг хандлага өөрчлөгдөн, насан туршийн боловсролын үзэл баримтлалыг чухалчилж байна. Насан туршийн боловсрол нь хүний боловсрол эзэмших эрхийн салшгүй нэг чухал хэсэг бөгөөд хүмүүнлэг ёс, ардчиллын үнэт зүйл, тэгш хамруулах зарчимд тулгуурласан, мэдлэгт суурилсан суралцагч нийгмийн үндэс юм (Steve & Nathan, 2011, p.13). Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) -аас НБТ-г дэлхий дахины нийгэм-эдийн засгийн болон улс төрийн хямрал, уур амьсгалын өөрчлөлт, мөн боловсролын өмнө тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх, даван туулах чухал хэрэгсэл хэмээн тодорхойлсон байдаг (Батчулуун нар, 2013, х.93). Манай улсад насан туршийн боловсролын талаар 2000-аад оны эхэн үед эрдэмтэн судлаачид өөрийн зохиол, бүтээлдээ эш татаж, тодорхой түвшинд судалж ирсэн. Улмаар 2014 онд НТБ-ын талаар баримтлах бодлогыг албан бус боловсролын бодлого, агуулга, арга зүй, үйл ажиллагааны менежментэд тусган хэрэгжүүлж эхэлсэн онцлогтой юм. ЮНЕСКО болон дэлхийн ихэнх улс орон, ялангуяа Европын улсууд насан туршийн боловсролын хүрээнд насанд хүрэгчдийн боловсролын асуудлыг голчлон авч үзэж байна (Батчулуун, 2019, х.15). Тиймээс НТБ-ын багшийн мэргэжлийг хөгжингүй улс орнуудад насанд хүрэгчдийн боловсролын багш (adult education teacher), насанд хүрэгчдийн боловсролын мэргэжилтэн (Adult educator) хэмээн нэршиж, багш нарыг насанд хүрэгчдэд сургалт зохион байгуулах агуулга, арга зүйд мэргэшүүлэх замаар бэлтгэн хөгжүүлж иржээ (Хонгорзул & Эрдэнэцэцэг, 2020, х.46). Харин манай улсын хэмжээнд анх *“Албан бус боловсролын үйлчилгээг насан туршийн тасралтгүй боловсролын тогтолцоо болгон өргөжүүлж ..., мөн НТБ-ын бодлого, төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиг үүргийг үндэсний хэмжээнд НТБ-ын үндэсний төв, орон нутагт аймаг, нийслэлийн боловсролын газар, НТБ-ын төв болон сумын НТБ-ын нэгж хэрэгжүүлнэ”* (Насан туршийн боловсролын талаар баримтлах чиглэл, 2014, х.3) хэмээн Албан Бус Боловсрол (АББ)-ын салбарын бүрэлдэхүүний тодорхойлолтыг өөрчилснөөр “НТБ-ын багш” хэмээх нэр томъёог хэрэглэх болжээ. Тиймээс НТБ-ын багшийг АББ-ын багшаар төлөөлүүлэн ойлгож, өдгөө 500 орчим багш нийслэл, аймаг, орон нутгийн 350 гаруй НТБ-ын төв, нэгжид ажиллаж байна (Насан туршийн боловсролын үндэсний төв, 2019, х.3). НТБ төв нь бүх насны иргэдийн хэрэгцээнд тулгуурласан боловсролын үйлчилгээ үзүүлэхэд чиглэдэг учраас НТБ-ын боловсролын багш нь хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид гэсэн бүхий л насны субьекттэй ажилладаг мэргэжлийн онцлогтой юм. Нөгөөтээгүүр эрдэмтэн судлаач Батчулуун “НТБ-ын багш нь ЕБС-ийн тодорхой нэг судлагдахууны багшаас илүү өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, олон талын мэдлэг, ур чадвартай байх шаардлагатай” хэмээн мэргэжлийн онцлогоос хамаарсан НТБ-ын багшийн мэргэжлийн чадамжийн талаар дурдсан байна (Батчулуун, 2012, х.21). Манайд НТБ-ын багш хэмээх шинэ мэргэжил бий болж мэргэжилтэн бэлтгэх болсон хэдий ч уг мэргэжлийн эрх зүйн орчин (ажил мэргэжлийн тодорхойлолт, албан тушаалын тодорхойлолт, НТБ-ын багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх журам г.м.) бүрдээгүй, НТБ-ын багшийн мэргэжлийн үйл ажиллагаа, багшийн ажлын ачаалал, мэргэжлийн хөгжил, багшийг мэргэшүүлэх чиглэл, мэргэжлийн хүрээнд ажиллахад шаардлагатай чадамж тодорхойгүй байна.

Тиймээс бидний судалгааны зорилго нь насан туршийн боловсролын багш мэргэжилтний эзэмшвэл зохих чадамжийг тодорхойлоход чиглэнэ.

Судалгааны арга зүй

НТБ-ын багшийн чадамжийг судалсан олон улсын туршлагыг судалж үзэхэд судалгааны дэльфи аргыг 2-3 үе шаттай хэрэгжүүлсэн туршлага дэлхийн нийтийн жишиг болсон байна (Хонгорзул, 2021, х.51). Бидний судалгаандаа хэрэглэсэн дэльфи арга нь анх 1950-1960-аад онд Америкийн Нэгдсэн Улсын бизнесийн салбарын Ранд корпорацын ажилтнууд боловсруулж хэрэглэсэн ба түүнээс хойш эрүүл мэнд, батлан хамгаалах, боловсрол, мэдээллийн технологи, тээвэр ложистик, инженерчлэл гэх мэт салбарт өргөн хэрэглэдэг болсон (Ravonne, 2014, p.2). Дэльфи аргыг ихэвчлэн судалж буй асуудал, үзэгдлийн талаарх ойлголт, мэдээлэл, чиглэл тодорхойгүй буюу одоогоор байхгүй байгаа зүйлийг илрүүлэхэд ихэвчлэн хэрэглэдэг (Adler & Ziglio, 1996, p.1). Тиймээс аливаа асуудлын талаар тусгайлан хэлэлцэх, урьдчилан таамаглах, шийдвэр гаргах (Rowe & Wright, 1999, p.2), бодлого төлөвлөх, удирдлагын стратеги боловсруулалтын хэрэгсэл (Delbeq et al, 1975, p.365) болгон ашиглаж байна. Энэхүү арга нь зорилтот бүлгийн түүвэрт тулгуурлан тэдний санал, дүгнэлтийг цуврал асуулгаар цуглуулж, хэлэлцүүлэг - боловсруулалт - хэлэлцүүлэг - боловсруулалт гэсэн зарчмаар хоёр ба түүнээс дээш үе шат (цикл хэлбэр)-аар тодорхой давтамжтай зохион байгуулдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл дараагийн шатны асуулга бүрийг өмнөх санал асуулгын үр дүнд үндэслэн боловсруулж, өмнөх үе шатны үр дүнг илүү нарийвчлан “Зөв” хариулт руу чиглүүлж өгдөг (Lattke & Zhu, 2010, p.96) бөгөөд асуудлын хариулт, шийдлийг тодорхойлсон тохиолдолд асуулга зогсдог байна. Багшийн чадамж, багш мэргэжилтэнд тавигдах нийтлэг шаардлагын талаар манай улсын хэмжээнд болон олон улсын түвшинд судалсан судалгааны үр дүн, шинжлэх ухааны тодорхойлолтууд цөөнгүй бөгөөд тогтсон ойлголт, утга агуулгатай болсон (Хонгорзул, 2021, х.35). Ялангуяа багшийн чадамж, багш мэргэжилтний зайлшгүй эзэмшсэн байх мэргэжлийн мэдлэг, чадварыг олон эрдэмтэн судлаач, багшийн үүрэг хариуцлага, мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд тодорхойлжээ. Багшийн чадамжид суралцахуйг төлөвлөх, зохион байгуулах сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх хийгээд мэргэжлийн заах арга зүйн мэдлэг, чадвар, хүүхэдтэй болон бусадтай хамтран ажиллах мэдлэг, чадварыг агуулдаг байна (Хонгорзул, 2021, х.36). Багшийн үүрэг хариуцлага талаасаа мэргэжлийн онцлогтой холбоотойгоор хүнлэг энэрэнгүй, өндөр ёс суртахуунтай, тасралтгүй хөгждөг, хамтач нийтэг, хичээнгүй зэрэг бие хүний шинж чанар, хандлага, үнэт зүйлтэй мэргэжил юм. Тийм учраас багшийн чадамж нь багшийн ажлыг мэргэжлийн түвшинд үр дүнтэй хийж гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвар, бие хүний шинж, хандлага, үнэт зүйлийн нэгдлээр тодорхойлдог бөгөөд бид насан туршийн боловсролын багшийн чадамжийг судлахдаа энэ хүрээгээр авч үзэх нь зүйтэй хэмээн үзлээ. Хоёр үе шаттай дэльфи асуулгын судалгаанд НТБ-ын үндэсний төв (хуучин нэр)-ийн мэргэжилтэн, аймаг дүүрэг, сумдын НТБ-ын төвийн багш, удирдах ажилтан, НТБ-ын багшийн ангийн оюутнаас бүрдсэн нийт 97 оролцогчийг хамруулав (Хүснэгт 1).

Table 1
Basic information of participants of the survey

Indicators	Total		Managers		Other professional teachers of LLE center		Alumni and students of LLE teacher program	
	n	%	n	%	n	%	n	%
Participants	97	100%	18	19%	63	65%	16	16%
Gender	Male		4	4%	11	11%	5	5%
	Female		14	14%	52	54%	11	11%
Experience	1-5		3	3%	33	34%	8	8%
	6-10		5	5%	15	15%	-	
	11-15		4	4%	7	7%		
	Above - 16		6	6%	8	8%		
Educational degree	Diploma		-		4	4%	-	
	Bachelor		6	6%	57	59%	8	8%
	Master		12	12%	2	2%	-	
Major	Teacher		14	14%	58	60%	8	8%
	Non-teacher		4	4%	5	5%	-	

Бид НТБ-ын багшийн чадамжийг тодорхойлох судалгааны арга зүйг дэльфи аргын онцлогт тулгуурлан 2 үе шатаар боловсруулж, үр дүнг фокус бүлгийн ярилцлагаар хэлэлцэж үр дүнгээ тогтоов.

I үе шат:

Бэлтгэл үйл ажиллагаа: НТБ-ын цогц чадамжийн хүрээнд бид НТБ-ын багш бие хүний шинж, багшийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлийг илрүүлэх нээлттэй асуулгын хуудас боловсруулсан. Ингэхдээ дэльфи аргын бүтцийн дагуу оролцогч судалгааны өгөгдөлдөө өөрийн үнэлгээ өгөх боломж олгоход чиглэсэн Лайкертийн шкаллаар өгөгдлийг эрэмбэлэх хэсгийг тусган асуулгын хуудсыг урьдчилан боловсруулсан.

Мэдээлэл цуглуулах аргачлал: Судалгаанд оролцогчидтой ганцаарчлан уулзаж судалгааны зорилго, зориулалт, ач холбогдол, асуулга бөглөх заавар, анхаарах зүйлийг тайлбарлана. Тухайлбал багш бие хүний шинж, мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлийн талаарх ойлголт, ялгагдах шинж зэрэг нэмэлт мэдээлэл өгч, уг асуулга нь 2 үе шаттайгаар хийгдэж дахин судалгаанд үргэлжлүүлэн хамрагдахыг хүсэж, тэдэнд асуулгын хуудсыг өгч санал дүгнэлтийг авна.

Эхний шатны үр дүнгийн боловсруулалт: Асуулгын үр дүнд бүрдүүлсэн насан туршийн боловсролын багш бие хүний шинж, мэдлэг, чадвар, үнэт зүйл хандлагаас лайкертийн шкалын эрэмбийн IV ба V-д сонгогдсон бүх өгөгдлүүдийг түүвэрлэсэн. Үүнээс агуулгын давхцал, ижил утгат хэсгүүдийг нэгтгэн бүлэглэж, тэдгээрийн давтамжийн эзлэх хувиар боловсруулан НТБ-ын багшийн бие хүний n_1 шинж, n_2 мэдлэг, n_3 чадвар, n_4 хандлага, n_5 үнэт зүйлийг тодорхойлсон.

II үе шат:

Судалгааны бэлтгэл үйл ажиллагаа: I шатны үр дүнд бүрдүүлсэн НТБ-ын багшийн бие хүний n_1 шинж, n_2 мэдлэг, n_3 чадвар, n_4 хандлага, n_5 үнэт зүйлийн жагсаалтыг эзлэх хувиар ихээс бага уруу нь жагсаалт гарган, оролцогчдоос лайкертын шкаллаар сонголтыг хийлгэх, мөн нэмэлтээр оруулах шаардлагатай өгөгдлийг асуулт бүрийн дор нээлттэй авахаар дахин асуулгын хуудас боловсруулсан. Ингэхдээ google form-ын асуулгын хуудсыг ашиглаж, интернэтэд байрлуулна.

Мэдээлэл цуглуулах аргачлал: Интернэт байрлуулсан асуулгын хуудсаа зөвхөн эхний шатны судалгаанд оролцсон оролцогчдын электрон хаягаар нь илгээж, онлайнар зохион байгуулна. Оролцогчдод утсаар мэдэгдэж судалгаанд хамрагдахыг санал болгоно.

Үр дүнгийн боловсруулалт: Асуулгын үр дүнг өгөгдөл тус бүрд хамгийн их сонголт авсан давтамж, эзлэх хувиар жагсааж, 90 хувиас дээш үнэлгээтэй үзүүлэлтүүдийг сонгож (Bernhardsson & Lattke, 2011, p.29) НТБ-ын багшийн цогц чадамжийн агуулгын хүрээг тодорхойлно. Шалгууруудын найдварын зэргийг бие хүний шинж, мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйл тус бүрээр SPSS-20 программын үзүүлэлтүүдийн дотоодын нийцлийн индекс кронбахын коэффициент (α) - ээр шалгаж баталгаажуулна. Дэльфи асуулгын үр дүнгээр тодорхойлогдсон чадамжийн агуулгыг засаж сайжруулах, үнэлгээ дүгнэлт авах, эцсийн хувилбарыг тодорхойлох, түүнийг баталгаажуулахад чанарын үнэлгээ хийхэд чиглүүлэн фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулна.

Фокус бүлгийн ярилцлага

Бэлтгэл үйл ажиллагаа: НТБ-ын багшийн бие хүний n_1 шинж, n_2 мэдлэг, n_3 чадвар, n_4 хандлага, n_5 үнэт зүйлтэй танилцуулан, дараах асуултуудын дагуу ярилцлагыг зохион байгуулна. Үүнд: i) НТБ-ын багш бие хүний шинжид өгөх санал дүгнэлт, ii) НТБ-ын багшийн эзэмшвэл зохих мэдлэгт өгөх санал дүгнэлт, iii) НТБ-ын багшийн эзэмшвэл зохих чадварт өгөх санал дүгнэлт, iv) НТБ-ын багшийн хандлага, итгэл үнэмшилд өгөх санал дүгнэлт, v) НТБ-ын багшийн үнэт зүйлд өгөх санал дүгнэлт орно.

Ярилцлагыг зохион байгуулах аргачлал: Ярилцлагыг судлаач хөтлөн явуулж, ярилцлагын бичлэгийн хуулбар (transcript)-ийг хийж, түүнийг нарийвчлан уншсаны эцэст гол санааг кодолж, анхан шатны боловсруулалт хийнэ.

Үр дүнд хийх боловсруулалт: Асуулт бүрээр фокус бүлгийн хариултын матрицад анализ хийж, үндсэн санааг ялган тэмдэглэж, багшийн цогц чадамжийн агуулгын сүүлийн хувилбарыг тогтооно.

Судалгааны үр дүн

Судалгааны дэльфи асуулгын үр дүнд дараах НТБ-ын багш бие хүний 14 шинж, 13 мэдлэг, 16 чадвар, 7 хандлага, 8 үнэт зүйлсийг тодорхойлов (Хүснэгт 2).

Table 2

Knowledge, skill and attitudes of lifelong learning teacher as revealed by delphi questionnaire

Criteria	Indicator	Mean	Std, Deviation	The results of the open field of additional offers and their frequency percentage
Personal characteristics of the LLE teacher	Be a role model and leader	4.15	.767	No additional comments or above all (18%) Versatile and flexible (9%) Capable of handling loads, fast and hardworking (9%) Humane compassion with a heart for others (7%) Does not discriminate and treats everyone equally (6%) Ability to work in a team (5%) Self-development (5%) Punctual and work with a plan (4%) Management (3%)
	Have extensive knowledge in multiple fields	4.58	.782	
	Be humane and compassionate	4.61	.778	
	Have a humble attitude	2.32*	.871	
	Like the profession	4.42	.496	
	Be smart and resourceful	2.33*	.927	
	Treat others well and have good communication skills	4.60	.623	
	Value ethical standards and be ethical	4.14	.767	
	Not discriminate and treat equally people	3.88*	1.011	
	Be diligent and hardworking	4.31	.868	
	Be responsible and well organized	4.25	.695	
	Be honest and principled	4.07	.694	
	Be creative and innovative	4.49	.612	
	Be patient and persistent	4.30	.807	
Knowledge of the LLE teacher	Have good knowledge of teaching methodology, psychology or pedagogy	4.55	.685	No additional vote or considered all of the above included (14%) Knowledge of teaching methods, adult education and psychology (12%) Knowledge of finance, economy and management (8%) Communication skills (6%) Understanding and knowledge of culture and aesthetics (5%) Understanding and knowledge about child development and family (4%) Awareness and knowledge of sustainable development (4%) General knowledge (4%) Knowledge of traditional customs (3%)
	Have theoretical and technical knowledge of the profession	4.84	.427	
	Have knowledge of IT and general application software	4.33	.683	
	Have knowledge of teaching at elementary education level	4.05	.854	
	Have knowledge of foreign languages	3.57*	1.181	
	Have knowledge of native language	4.12	.832	
	Have knowledge of life science content and soft skills	4.25	1.146	
	Have knowledge of special needs education and inclusive education	4.02	.940	
	Have knowledge of law	3.48*	1.086	
	Have knowledge of family education	4.03	1.171	
	Have knowledge of research methodology	4.00	.749	
	Have knowledge of healthcare	4.09	.970	
	Have knowledge of economics	3.27*	1.083	
	Skills of the teacher of LLE	Be able to communicate with others	4.52	
Be able to work in a team with others		4.50	.700	
Be able to adapt to the profession		4.81	.445	

	Have good verbal and presentation skills	4.38	.599	Good personal organization and time management (5%)
	Be able to manage and organize	4.08	.947	The ability to listen to others and take words (4%)
	Be able to perform research work	4.25	.905	Ability to build partnerships (4%)
	Be able to be independent, continuous and self-developing	4.58	.667	Mentoring others (3%)
	Be able to work with and process information	4.75	.480	Talented and athletic (3%)
	Be able to plan and manage time	4.08	1.370	Integrity (3%)
	Be able to work in an electronic environment	4.73	.490	
	Be able to develop programs	4.23	1.002	
	Be able to organize training and implement programs	4.81	.398	
	Be able to solve problems and make decisions	4.25	.905	
	Be able to apply knowledge and use it creatively	4.33	.901	
	Be able to work with people from different social groups	4.79	.457	
	Be able to influence others and lead	4.71	.498	
Attitudes of the teacher of LLE	Have positive communication attitude and opinion	4.52	.562	Caring for others (18%)
	Be sincere and selfless in yourself work	4.46	.501	None or all of the above (15%)
	Have willingness to continuously develop	4.51	.722	Passionate about work (13%)
	Respect and accept others	4.39	.641	Honesty (8%)
	Be optimistic, passionate and purposeful	4.16	.707	Persistence (5%)
	Be able to expresses one's opinion correctly, have positive thoughts, and be kindhearted	4.13	.694	Passionate and determined (5%)
	Have a creative and active approach to any problem	4.75	.490	Kind (4%)
Values of the teacher of LLE	Improve the quality of human life and influence it	4.76	.458	No additional vote or considered all of the above included (16%)
	Use opportunities for teacher development	4.26	.798	A wide range of activities for all (16%)
	Work in branch organizations and communities	4.08	.815	Ability to develop multi-skills and flexibility (9%)
	Be able to create positive change and development in students	4.31	.714	Guides others to the right lifestyle (7%)
	Respect the reputation of the teacher or the professional value of the teacher	4.10	.617	
	Work with all people without discrimination	4.93	.260	
	Enlighten citizens and lead to development	4.85	.417	

Work for others and for the good of people	4.69	.603
--	------	------

*Судалгааны үзүүлэлтүүдээс сонгогдох нөхцөлийг хангаагүй буюу математик дундаж утга 4 ба түүнээс доош (Bernhardsson & Lattke, 2011, p.32)

НТБ-ын багшийн цогц чадамжийн шалгуурт багтсан үзүүлэлт тус бүрийн нийцтэй байдал, найдварын зэргийг кронбахын альфа коэффициентоор шинжиж үзэхэд 0.672 - 0.844 хооронд гарсан нь судалгаагаар илрүүлсэн үзүүлэлтүүд найдварыг илтгэж байна (Хүснэгт 3).

Table 3
Reliability of research results

Criteria	Noun	Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items
Personal characteristics of the LLE teacher	14	.781	.788
Knowledge of the LLE teacher	13	.822	.805
Skills of the LLE teacher	16	.844	.841
Attitudes of the LLE teacher	7	.714	.721
Values of the LLE teacher	8	.672	.667
Average	11.8	.766	.764

Нийгмийн шинжлэх ухааны салбарт кронбахын коэффициентын утга 0.7 - руу дөхсөн, эсвэл түүнээс их байвал “хүчин төгөлдөр” гэж үздэг.

Фокус бүлгийн ярилцлагыг нэг удаа хийсэн бөгөөд НТБ-ын салбарт 13 ба түүнээс дээш жил ажилласан багш, сургалтын менежер, захирал, үндэсний төвийн мэргэжилтний төлөөлөл 11 оролцогчийг хамруулав (Хүснэгт 4).

Table 4
Data from focus group interview participants

№	Code	Experience		Current and former positions
		In education sector	Of this, in the LLE	
1	O-1	30	18	2003-2009, Part-time teacher at “Gegeerel” center 2009-2014, Teacher at “Gegeerel” center 2014- present, Teacher at LLE center
2	O-2	31	21	1989-1996, Secondary school teacher 1996-1999, Secondary school manager 1999-present, Teacher and principal at LLE center
3	O-3	35	24	1997-present, Researcher, specialist at National Institute of LLE
4	O-4	18	13	2002-2007, Secondary school teacher 2007-present, Teacher at center of LLE
5	O-5	36	23	1984-1997, Secondary school teacher

				1997-1999, Principal of the Gegeerel center 1999 – present, Specialist at National Institute of LLE
6	O-6	35	20	1985-2000, Teacher and manager at secondary school 2001- present, Principal of center of LLE
7	O-7	20	20	2001- present, Teacher at center of LLE
8	O-8	35	20	1985-1988, Secondary school teacher 1988-2000, Manager of secondary school 2000- present, Principal of center of LLE
9	O-9	24	13	1996-2002, Kindergarten teacher 2002-2007, Social worker of “World vision” international organization 2007- present, Teacher and manager at center of LLE
10	O-10	25	17	1990-2001, Secondary school teacher 2001- present, Teacher and manager at center of LLE
11	O-11	20	20	2001 – present, Manager at center of LLE

Ярилцлагад оролцогчдын боловсролын салбарт ажилласан жилийн дундаж 28.4 жил, НТБ-ын салбарт ажилласан жилийн дундаж 19 байв. Оролцогчдын эрхэлж буй албан тушаалыг авч үзвэл: Багш - 3 (27%), сургалтын менежер - 3 (27%), төвийн захирал - 3 (27%), үндэсний төвийн мэргэжилтэн - 2 (18%) байсан бөгөөд оролцогчдын дийлэнх нь уг салбарт багш, удирдах ажилтнаар ажиллаж байсан туршлагатай байна. Ярилцлагын үр дүнд шинжилгээ хийхэд ярилцлагын чиглэлд мэргэжилтний нэр томьёо байгаагүй ч ярилцлагын эхэнд оролцогчдын зүгээс нэр томьёонд асуудал байгааг илэрхийлснээр, “багшийн нэр томьёонд өгөх санал дүгнэлт” гэсэн бүрэлдэхүүн нэмэгдсэн юм. НТБ-ын багш мэргэжилтний нэр томьёоны хувьд: Үйл ажиллагааны субъект, мэргэжлийн гол онцлог нь насанд хүрэгчидтэй ажилладаг байдал. Тиймээс “Насанд хүрэгчдийн багш”, “Нийгмийн сурган хүмүүжүүлэгч” болон “Багш судлаач” гэж томьёолох санал гарсан (Эшлэл 1).

Эшлэл 1 ... Яагаад ЕБС-ийн математикийн багш насанд хүрэгчдийн сургалтад үйлчлээд байна. Нэр томьёоны хувьд бол төөрсөн. Анх биднийг энэ салбарыг хөгжүүлэх гээд гадагшаа, дотогшоо их туршлага судлуулдаг байсан. Тухайн үед “Насанд хүрэгчдэд ЕБС-ийн багш сургалт үйл ажиллагаа явуулдаг” гэхэд их гайхаж хүлээж авдаг байсан. Яагаад багш хүн, тэр тусмаа “ЕБС-ийн багш насанд хүрэгчдийн боловсролыг дээшлүүлж байна вэ? Энэ хүн ЕБС-д л багшлах ёстой” гээд. Насан туршийн боловсролын багшийн хамгийн гол онцлог ялгаа бол насанд хүрэгчидтэй ажилладаг байдал шүү дээ. Эхний удаа бид энэ нэр томьёогоо цэгцлэх хэрэгтэй байна.

Бүлгийн ярилцлагаас О-8

Дээрхээс харахад НТБ-ын багшийн үйл ажиллагаа нийгэмд чиглэсэн, насанд хүрэгчидтэй ажилладаг тул энэ онцлогтой нь холбож томьёолох санал нийтлэг байна. Мөн НТБ-ын багшийн нэр томьёоны нэгдсэн ойлголт, үндсэн үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй байгаад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж буй нь ярилцлагын явцад ажиглагдсан юм. Эндээс үзэхэд НТБ-ын багшийн нэр томьёог

тодорхойлоход шаардлагатай судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, эрх зүйн баримт бичгүүд, мэргэжлийн тодорхойлолтыг шинээр боловсруулж мөрдөх, салбарын санхүүжилтийг шинэ чиг хандлага, үндсэн зорилготой уялдуулан төлөвлөх нь бодит хэрэгцээ болоод байна гарсан (Эшлэл 2-3).

Эшлэл 2 ... НТБ-ын багшийн ажил мэргэжлийн хүрээ байдаггүй. ЕБС-ийн багшийн адил байдаг. НТБ-ын багш бага ангийн багш, НТБ багш дунд ангийн багш гэдэг. Энэ байдал нь салбарын удирдах ажилтан, нэгж дээр ажиллаж буй багш нарт хүрэхдээ ташаа ойлголт үүсгэж, төөрөгдөлд хүргэдэг.

Бүлгийн ярилцлагаас О-5

Эшлэл 3 ... НТБ-ын багшийн хувьд бол насанд хүрэгчдийн сургалыг зохион байгуулах нь яах аргагүй үндсэн үйл ажиллагаа байдаг. Гэтэл манайд санхүүжилтээсээ болоод дүйцсэн хөтөлбөрийн сургалтад бид түлхүү анхаарч ирсэн нь салбарын хөгжил, цаг үеийн шинэ шаардлагатай төдий л нийцэж хөгжиж чадахгүй байна.

Бүлгийн ярилцлагаас О-6

НТБ-ын багш бие хүний шинжид өгөх санал дүгнэлт: Үүнд: Хүсэл тэмүүлэл; - зорилготой байх; -Тэвчээртэй байдал; -Хариуцлагатай байдал; -Ёс зүйтэй байх; - Хувийн зохион байгуулалт; -сахилга баттай байх; -Өөрийгөө мэддэг; -өөрийнхөө давуу, сул талаа олж, таньсан байх зэрэг болно (Эшлэл 4).

Эшлэл 4 ... НТБ-ын багшийн асуудал нь их өргөн хүрээтэй үйл ажиллагааг зохион байгуулдагтай холбоотой. Өөрөөр хэлбэл, багш нь манай улсын хүн амын хөгжлийн индекс хаана байгаагаас шалтгаалж бид бичиг үсгийн боловсролын асуудал, хүний нөөцийн асуудал эсвэл насан туршдаа суралцахуйн асуудлыг барьж авах уу гэдэг талаар судалсан, шинжилсэн зүйл байдаггүйгээс хамаарч багшийн үйл ажиллагаа чиглэл одоо хүртэл тодорхойгүй байгаа юм. Тиймээс бид багшийн албан тушаалын тодорхойлолт, ажил мэргэжлийн хүрээгээ тодорхойлж чадахгүй байна.

Бүлгийн ярилцлагаас О-3

Ярилцлагаас харахад, НТБ-ын салбарт үүссэн багшлах боловсон хүчний дутагдалтай байдал, өнөөгийн практикт хэрэгжиж буй үндсэн үйл ажиллагаа болох дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж буй сургууль завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад боловсролын үйлчилгээ үзүүлж буй онцлогтой ихээхэн холбоотой багш бие хүний шинжүүдийг дурдсан нь дэльфи асуулгын үр дүнг бататгасан үзүүлэлт байна.

Багшийн эзэмшвэл зохих мэдлэгт өгөх санал, дүгнэлт: Янз бүрийн насны хүмүүсийн онцлог, тэдний сурах арга барилын талаарх мэдлэг, Дүйцсэн хөтөлбөрийн талаарх мэдлэг, Компьютер, орчин үеийн техник технологийн талаарх мэдлэг, Зөв бичих дүрмийн мэдлэг, НТБ-ын 5 чиглэлээс 1 чиглэлийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай мэдлэг, чадвар, Ажлын байрандаа хөгжих аргын талаарх мэдлэг зэргийг нэрлэсэн (Эшлэл 5-6).

Ишлэл 5. Орон тоо цөөн, их ачаалалтай ажилладаг. Тиймээс хувийн зохион байгуулалттай, сахилга баттай, насанд хүрэгчидтэй ажилладаг учраас ёс зүйтэй байхыг их шаарддаг.

Бүлгийн ярилцлагаас О-3

Эшлэл 6. Бид насанд хүрэгчдэд байнга сургалт зохион байгуулдаг учраас өөрийгөө байнга хөгжүүлэх шаардлагатай байдаг. Тиймээс ажлын байрандаа хөгжих арга замаа мэддэг баймаар байна.

Бүлгийн ярилцлагаас О-10

Судалгаанд оролцогчид НТБ-ын багшийн эзэмшвэл зохих мэдлэгийг НТБ-ын сургалтын агуулга, цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой зайн сургалтыг зохион байгуулахад шаардлагатай онол, арга зүйн өргөн мэдлэгтэй байхыг чухалчилсан юм. Мөн НТБ-ын багш нь дүйцсэн хөтөлбөрийн сургалт зохион байгуулахын зэрэгцээ, “НТБ-ын 5 чиглэлийн сургалтыг зохион байгуулахад шаардлагатай шинжлэх ухааны түвшний ойлголт мэдлэг нэн шаардлагатай, дутагдаж байна” хэмээгээд, зайлшгүй тусгах мэдлэг болохыг тэмдэглэжээ.

Багшийн эзэмшвэл зохих чадварт өгөх санал, дүгнэлт: НТБ-ын багш дараах чадваруудыг эзэмшсэн байх ёстой гэж судалгаанд хамрагдагсад дурдсан. Үүнд: Холимог бүлгийн сургалтын арга зүй эзэмшсэн; -Олон нийтийн нөлөөллийн ажлын арга зүй эзэмшсэн; -Насанд хүрэгчдийн сургалтын арга зүй эзэмшсэн; -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй эзэмшсэн; -Амьдрах ухааны боловсролын арга зүй эзэмшсэн; -Багаар ажиллах чадвартай; -Хөрвөх чадвартай; -Компьютер дээр ажиллах чадвартай; -Эх хэлээрээ зөв найруулж бичих; -Албан

Эшлэл 7. ... дор хаяж 10, 20 өөр өөр сургалт, үйл ажиллагааны арга зүй эзэмшсэн байвал маш сайн болов уу? Бид “Насанд хүрэгчдийн сургалт зохион байгуулна л” гээд байна. Яаж зохион байгуулах вэ? гэхээр л арга зүй дээр унаад байдаг. Өөрөөр хэлбэл, “Насан туршийн боловсролын багш яг ийм ийм арга зүй эзэмшсэн байх ёстой” гээд жагсаагаад өгчихвөл бүр тодорхой болно.

Бүлгийн ярилцлагаас О-8

Эшлэл 8. ... Насан туршийн боловсролын салбарт дүйцсэн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг маш их туршлага бий болсон. Энэ нь холимог бүлгийн арга зүйгээр хэрэгждэг учраас бид холимог бүлгийн арга зүйд сайн суралцах шаардлагатай. Мөн асуудал, сургалтын агуулга, арга зүйг интеграцилж чаддаг...

Бүлгийн ярилцлагаас О-5

бичиг боловсруулах чадвар (хөтөлбөр, төлөвлөлт, хурлын тэмдэглэл, тайлан гм.); -Анализ хийх чадвартай; -Шинэ санаа дэвшүүлдэг, түүнийгээ хэрэгжүүлдэг чадвартай; -Чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх арга зүйтэй; -Судалгааны өгөгдөлтэй ажиллах чадвартай; -Цаг үеийн өөрчлөлт, шинэчлэлийг дагаж хөгжих чадвартай; -Судалгааны үр дүнг ажилдаа ашиглах чадвартай; -Харилцааны ур чадвартай; -Илтгэх ур чадвартай; -Өөрийгөө илэрхийлэх, үнэлэх чадвартай. НТБ-ын багшийн эзэмшвэл зохих чадварт өгсөн саналаас харахад багшаас сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах арга зүйн болон хувь хүний, мэргэжлийн өсөлт хөгжлөө хангахад шаардлагатай чадваруудыг эзэмшихэд чиглэжээ. Энэ нь өмнөх судалгааны үр дүнг харьцангуй тодорхой болгох, төрөлжүүлэх, баяжуулахад түлхэц болно хэмээн үзэж байна (Эшлэл 7-8).

Багшийн хандлагад өгөх санал, дүгнэлт: Судалгаанд хамрагдсан хүмүүс дараах хоёр хандлагыг НТБ-ын багш заавал эзэмшсэн байх ёстой гэж үзсэн. Үүнд: Зорилтот бүлгийнхэнтэй ажиллах сэтгэл зүйн бэлтгэлтэй байх; -Хувь хүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж, ойлгодог байх (Эшлэл 9).

Багшийн эрхэмлэх үнэт зүйлд өгөх санал дүгнэлт: Харин НТБ-ын багшийн үнэт зүйл нь бусдаас суралцдаг байх гэж дийлэнх нь үзсэн.

Судалгаанд оролцогчдын саналаас харахад, дэльфи асуулгын үр дүнд гарсан багшийн харилцаа хандлага, үнэт зүйлийн шалгуурууд нь багшид шаардлагатай зүйлийг бүрэн дүүрэн илэрхийлсэн болохыг илтгэж байна. Харин багшийн сургалт, үйл ажиллагаанд хамрагддаг субъектүүдийн өвөрмөц онцлогийг хүлээн зөвшөөрч, тэдэнтэй ажиллах сэтгэл зүйн болоод багшлах бэлтгэлтэй байх асуудлыг хөндсөн байна. Судалгаанд оролцогчид багш бие хүний хувьд насанд хүрэгчидтэй ажилладаг онцлогтой холбож хувийн зохион байгуулалт, сахилга

Эшлэл 9. Дүйцсэн хөтөлбөрийн суралцагчидтай ажиллахад сэтгэл зүйн бэлтгэх их шаарддаг. Бэрхшээл их гардаг. Тиймээс зорилтот бүлэгт зориулсан сайн дурын үйл ажиллагаанд их оролцдог баймаар байна. Тэгвэл ядаж сэтгэлзүйн хувьд ямар хүүхдүүд, иргэдтэй ажиллахаа урьдаас мэддэг, тэгээд сурсан мэргэжилдээ дур сонирхолтой болох болов уу?

Бүлгийн ярилцлагаас О-1

баттай, хариуцлагатай, ёс зүйтэй багш байхад чиглэсэн 5 шинжийг чухалчилсан нь дэльфи асуулгын үр дүнтэй харьцуулахад бичиглэлийн хувьд ялгаатай ч утга агуулгын хувьд ойролцоо үр дүнтэй байна. Тиймээс НТБ-ын багш бие хүний шинж нь Бүтээлч сэтгэлгээтэй, шинийг эрэлхийлэгч; -Хариуцлагатай, хувийн зохион байгуулалт сайтай; -Бусадтай зөв боловсон харилцдаг, харилцааны соёлтой; -Ес зүйн хэм хэмжээг эрхэмлэдэг, ёс зүйтэй; -Ажил мэргэжилдээ дур сонирхолтой; -Үлгэр жишээ, манлайлагч; -Ажилч хичээнгүй, хөдөлмөрч; -Үнэнч шударга, зарчимч; -Хүнлэг, энэрэнгүй; -Олон талын, өргөн мэдлэгтэй; -Тэвчээр хатуужилтай, тууштай; -Өөртөө итгэлтэй, өөрийн гэсэн үзэл бодолтой байх зэргээр тодорхойлогдож байна. НТБ-ын багшийн эзэмшвэл зохих мэдлэгт манай улсын өнөөгийн практикт хэрэгжиж буй дүйцсэн хөтөлбөрийн агуулга, арга зүйн талаарх ойлголт мэдлэг, уг сургалтад хамрагдаж буй суралцагчдын онцлогоо мэддэг, тэдний сурах арга барилд суралцахад нь дэмжлэг үзүүлэх, мөн НТБ-ын 5 чиглэлийн 1 чиглэлийн агуулгыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг чадвар дутагддаг учраас энэ талын мэдлэгтэй байх хэрэгтэй хэмээн үзэж 6 үзүүлэлтийг санал болгосон байна. Харин чадварын фокус бүлгийн ярилцлагад оролцогчид “Багшийн чадварын шалгуурыг нухацтай хэлэлцэх шаардлагатай” хэмээн үзээд, “сургалт - үйл ажиллагааг зохион байгуулах арга зүй сайтай байх” гэдэгт тэдний 87% нь нэмж тодруулах, нарийвчлах санал өгсөн бөгөөд үүнд судалгаа хийх чадвар, хөтөлбөр болон албан бичиг боловсруулах чадварыг зайлшгүй эзэмшихэд чиглэсэн 21 чадварыг санал болгосноос 8 чадварын агуулга, үзэл санаа асуулгын үр дүнтэй ижил байна. Харин 13 чадвар нь чадварын үзүүлэлтүүдийг баяжуулсан болно. Эдгээр мэдлэг, чадварын агуулгыг ойролцоо үйл ажиллагаа, чиглэлээр нь бүлэглэж үзэхэд НТБ-ын онол, үзэл баримтлал, агуулга, түүнийг хэрэгжүүлэх; -

Судлан шинжлэх; -Суралцагчдын онцлог, ялгаатай байдлыг харгалзан үзэх; - Суралцахуйг төлөвлөх, боловсруулах; -Сургалтын арга зүй тодорхойлох, хэрэгжүүлэх;- Багшийн мэргэжлийн хөгжлөө хангах; -Хамтын ажиллагааг бий болгох мэдлэг, чадвар гэсэн чиглэлтэй байна. Эдгээрийн агуулгыг доорх хүснэгтээр дэлгэрэнгүй үзүүлээ.

Table 5

Classification of the knowledge and skills of lifelong education teacher

№	Domain of the knowledge and skills	Knowledge and skills
1.	Content of the theory and concept of LLE and its implementation	<ul style="list-style-type: none"> - Knowledge of life science content and soft skills - Knowledge of family education - Knowledge of health education - Knowledge of law and legal education - Professional theoretical and scientific knowledge - Knowledge of economics and financial management - Knowledge necessary to organize training and activities in 1 of the 5 areas of the LLE - Knowledge of sustainable development education - Knowledge of traditional customs - Knowledge of the content of primary education
2.	Assessing and determining the learning and development needs of students	<ul style="list-style-type: none"> - Knowledge of research methodology - Ability to perform research work - Ability to work with and process information - Ability to work with research data - Ability to analyze - Ability to use research results in work
3.	Identifying student characteristics and differences	<ul style="list-style-type: none"> - Knowledge of the characteristics of people of different ages and their learning methods - Knowledge of the characteristics of the target group - Ability to work with people from different social groups and strata
4.	Planning and developing individual and group learning	<ul style="list-style-type: none"> - Knowledge of teaching methods, psychology and pedagogy - Knowledge of special needs education and inclusive education - Knowledge of equivalent programs - Ability to develop programs
5.	Defining and implementing teaching methods for children and youth	<ul style="list-style-type: none"> - Knowledge of computers and modern technologies - Ability to organize training and implement programs - Speaking and presentation skills - Planning and time management skills - Ability to manage and organize - Mixed group teaching method skills - Methodological skills of public influence work - Methodological skills of adults - Ability to work with disabled children - Methodological skills of life science education - Methodological ability to develop free thinking - Ability to work in an electronic environment
6.	Providing teacher's professional development	<ul style="list-style-type: none"> - Knowledge of correct spelling - Knowledge of ways to develop in the workplace - Ability to independently, continuously, and develop oneself

		<ul style="list-style-type: none"> - Ability to apply knowledge and use it creatively - Ability to change professions and learn new things - Problem solving skills - The ability to develop and adapt to the changes and innovations of the times - Self-esteem - Ability to influence others and lead - Ability to propose and implement new ideas
7.	Building relationships and collaboration	<ul style="list-style-type: none"> - Ability to express yourself - Communication skills - Ability to work with others - Partnership and communication skills - Ability to mentor others

НТБ-ын багшийн хандлагад хувь хүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж ойлгодог байхыг санал болгосон нь асуулгын үр дүнд тусгагдсан, мөн зорилтот бүлгийнхэнтэй ажиллах сэтгэл зүйн бэлтгэлтэй байх үзүүлэлтийг “мэдлэг” хэмээн үзэж мэдлэгийн жагсаалтад оруулсан тул багшийн хандлагын талаарх асуулгын үр дүн хэвээр тогтов. Харин НТБ-ын эрхэмлэх үнэт зүйлд фокус бүлгийн ярилцлагаас “бусдаас суралцдаг байх” үзүүлэлтийг нэмж санал болгосноор “ажлын болон суралцагч хамт олноос тасралтгүй суралцдаг байдал” гэсэн үзүүлэлтээр шинээр нэмэгдэж тодорхойлогдов.

Хэлэлцүүлэг

НТБ-ын багш мэргэжилтний нэр томъёоны хувьд судалгааны зорилго, чиглэл биш боловч судалгааны явцад салбарын хэмжээнд багшийн нэршлийг шинээр тодорхойлж, албан ёсоор мөрдөх журам, зохицуулалт зайлшгүй шаардлагатай болохыг илтгэж байна. Тухайлбал насан туршийн боловсролын багш гэдэг нэршлээс харахад боловсролын суурь зарчим, онолын үзэл баримтлалаар томъёологдсон байдалтай. Гэтэл Данийн эрдэмтэн Б.Валгрены насанд хүрэгчдийн боловсролын багшийн цөм чадамж (2016) судалгаанд зарим хөгжингүй улс орнуудын нэршил “Насанд хүрэгчдийн багш, сурган хүмүүжүүлэгч” гэж тэмдэглэсэн байгаад бид анхаарлаа хандуулах хэрэгтэй. Энэхүү судалгаагаар насан туршийн боловсролын багшийн чадамжид сургалтын онол, арга зүй, багшийн хөгжлийн чадамжууд түлхүү тодорхойлогдсон бол судлаач Б.Валгрены судалгаагаар насанд хүрсэн суралцагчдын сурсан зүйлээ практикт хэрэгжүүлэх, ашиглах боломжийг олгох чадамжуудыг илрүүлсэн үр дүнтэй харьцуулан үзэх шаардлагатай. Судалгааны үр дүнд НТБ-ын багш бие хүний шинж, хандлага, үнэт зүйлийг тодорхойлох боломжтой боловч, мэдлэг, чадварын хувьд ерөнхий, багшийн мэргэжлийн үйл ажиллагааг бүрэн хамарч чадаагүй байдлыг анхаарах шаардлагатайг тэмдэглэж байна. Тиймээс НТБ-ын багшийн цогц чадамжийг бусад улс орны цогц чадамжийн судалгааны үр дүнтэй харьцуулан, чадамжийн агуулга, бичиглэл, найруулгыг сайжруулах, илүү тодорхой болгон нарийвчлах, баяжуулах зэргээр өөрийн орны онцлог, олон улсын туршлагыг тусган тодорхойлох нь зүйтэй юм.

Дүгнэлт

НТБ-ын багшийн цогц чадамжийг багш бие хүний шинж, багшийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага, эрхэмлэх үнэт зүйл гэсэн аг уулгаар судлахад НТБ-ын багш бие хүний шинж, хандлага хоёрын агуулга бага зэрэг төстэй, мэдлэг чадварын агуулгын хоорондын хамаарал бага буюу өөр өөр мэдлэг, чадвараас бүрдсэн, чадварын агуулга бусад шалгууртай харьцуулахад багтаамж ихтэй тодорхойлогдлоо. НТБ-ын багш бие хүний шинжид багш мэргэжлийн нийтлэг шинжүүд тодорхойлогдсон бол, мэдлэг чадварын хувьд НТБ-ын чиг хандлагад баримжаалсан шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, агуулгын талаарх мэдлэгтэй байх, арга зүйн хувьд хүүхэд залуучууд, насанд хүрэгчдийн суралцах хэрэгцээ, сурах хэв маягийг тодорхойлох, холимог бүлгийн сургалтыг чиглүүлэх болон олон нийтийн төрөл бүрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хамтран ажиллах чадварууд багтаж байна. Харин тэдгээрийн томьёолол, бичиглэлийн хувьд ерөнхий, мэргэжлийн онцлогийг тусгасан агуулга бага, бүлэг чадваруудыг нэгтгэн агуулсан бүхэллэг шинжтэй буюу чадамжийн айн томьёололтой болох нь харагдаж байна. Мөн агуулгын багтаамжийн хувьд онол үзэл баримтлал, судлагдахууны мэдлэг, багшийн арга зүйн чадвар, багшийн хөгжлийн чиглэл түлхүү байна. Харин сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, боловсруулах, сургалтын орчин бүрдүүлэх болон багшлахуйн чадамж бага туссан байгааг багш нарын багшлахуйд тулгарч буй асуудал бэрхшээлтэй холбоотой үр дүн хэмээн дүгнэж болохоор байна. НТБ-ын багшийн хандлага нь бүх хүнд, ялангуяа сурч хөгжих, боловсрол эзэмшихэд янз бүрийн саад бэрхшээлтэй тулгарсан хүмүүст боловсролын үйлчилгээ үзүүлдэг, өөр өөр насны суралцагчидтай ажиллахад шаардлагатай итгэл үнэмшил, багш хүний үзэл бодол, байр сууриар тодорхойлогдсон нь уг мэргэжил нь багшаас тасралтгүй хөгжихийг шаардаж, хөгжих боломжтой байдал зэрэг нь тэдний мэргэжлийн үнэ цэнг нэмэгдүүлдэг нь харагдав. Нөгөө талаас, багш хаана ч, хэнтэй ч ажиллах хамтын ажиллагааны өргөн хүрээнд өөрийгөө хөгжүүлэх боломж ихтэй мэргэжлийн өвөрмөц онцлогоос хамаардаг байна.

Талархал

Энэхүү судалгаанд хамрагдаж өөрийн үнэтэй туршлага, санал дүгнэлтийг хуваалцсан НТБҮТ (хуучин нэрээр)-ийн мэргэжилтэн, аймаг нийслэлийн НТБ-ын төвийн удирдлага, багш нарт гүн талархал илэрхийлье.

Ашигласан бүтээлийн жагсаалт

Adler, M., Ziglio, E. (1996). *Gazing into the oracle: The Delphi Method and its application to social policy and public health*. London: Jessica Kingsley Publishers.

Bernhardsson, N., Lattke, S. (2011). Core competencies of adult learning facilitators in Europe. Retrieved from https://asemlllhub.org/wp-content/uploads/attachments/QF2TEACH_Transnational_Report_final_1_.pdf

Батчулуун, Е. (2012). Монгол улсын албан бус боловсролын тогтолцооны үүсэл хөгжил. *Боловсрол судлал сэтгүүл*, 07(85), 21-26.

- Батчулуун, Е. (2019). *Насан туршийн боловсролын дэд салбарын судалгааны тайлан*. Улаанбаатар: Содпресс.
- Батчулуун, Е., Гансүх, С., Гүндэгмаа, Д., Жадамба, Б., Мягмар, О., Отгонсүрэн, Л., Эрдэнэчимэг, Б. (2013). *Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол: Онол - арга зүй*. Улаанбаатар: АББ-ын хэвлэх газар.
- Delbeq, A., Van de Ven, A., Gustafson, D. H. (1975). *Group techniques for program planning: A guide to nominal group and Delphi processes*. USA: Foresman and Company.
- Насан туршийн боловсролын талаар баримтлах чиглэл* 2014. (БШУЯ). (Улаанбаатар).
- Насан туршийн боловсролын үндэсний төв. (2019). *НТБҮТ-ийн тайлан мэдээ - 2019*. Улаанбаатар.
- Хонгорзул, Б. (2021). Насан туршийн боловсролын багшийн цогц чадамжийг судалсан үр дүн. *Диссертаци*. Улаанбаатар.
- Хонгорзул, Б., Эрдэнэцэг, С. (2020). Насанд хүрэгчдийн багшийн цогц чадамжийн харьцуулсан судалгаа. *МУБИС-ийн Боловсролын бодлого, бодлогын шинжилгээ ЭШХ-ын эмхэтгэл, 45-53*.
- Lattke, S., Zhu, H. (2010). Competencies of teachers and trainers in adult education - Europe and China. Egetenmeyer.R., Nuissl.E (eds). *Teachers and trainers in adult and lifelong learning: Asian and European perspectives*. Frankfurt: Peter Lang.
- Ravonne, A. G. (2014). The Delphi technique in educational research. *SAGE Open* - Volume 4, Issue 2, 1-8. doi: <https://doi.org/10.1177/2158244014529773>
- Rowe, G., Wright, G. (1999). The Delphi technique as a forecasting tool: Issues and analysis. *International Journal of Forecasting*, 353-375. doi: [https://doi.org/10.1016/S0169-2070\(99\)00018-7](https://doi.org/10.1016/S0169-2070(99)00018-7)
- Steve, W. K., Nathan, E. P. (2011). *The Oxford Handbook of Lifelong Learning*. Londong: Manuel London.
- Wahlgren, B. (2016). Adult educators' core competences. *International review of education*, 62(3), 343-353. doi:[10.1007/s11159-016-9559-4](https://doi.org/10.1007/s11159-016-9559-4)

Determining the competencies of lifelong education teachers using the delphi method

Khongorzul Battulga*, Erdenetsetseg Sandui

*Department of Lifelong and Distance Education, School of Education Studies,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

Corresponding author: khongorzul@msue.edu.mn

Received: 13/10/2022

Revised: 14/11/2022

Accepted: 02/12/2022

Abstract

What are the competencies required for a professional teacher? What is the vital part of the teacher's professional development process? The questions continue to be a pressing issue in the field of educational research, policy, and legal documentation. In particular, although they have started to train new teachers at the Center for Lifelong Education, the areas of professional activities for teachers, the competencies required to perform, the job requirements are not clear enough, and the job descriptions have not been updated yet (for non-formal education teachers). Therefore, in order to determine the competences of the teacher of lifelong education, the Delphi method, which is widely used in international research in this field, has been used to determine the scope of the professional competences of the lifelong education teacher, and, based on the features of the method, the results were confirmed via focus group interviews. Based on the content of the teacher's competence in the educational policy of Mongolia, especially in the context of teacher's professional standards, we have considered the personal characteristics, knowledge, abilities, attitudes, and values of the teacher. About 110 participants took part in the study, including specialists from the National Center for Lifelong Education (the former name), teachers and administrators from the capital city and local Centers for Lifelong Education, as well as students majoring in this field. As a result of the research, a total of 80 indicators of the total competence of lifelong education teachers were determined: 12 personality traits, 51 knowledge skills, 9 attitudes, beliefs, and 8 values (Cronbach's α average 0.766). It can be classified into 7 areas of knowledge and skills: research; differentiated teaching; planning and developing learning; determining and implementing teaching methods; ensuring the professional development of teachers; and, knowledge and skills to create cooperation.

Keywords: Adult education, personality, knowledge, skills, attitudes, values